



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




## Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 3.5 хувиар өссөн байна

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2022 оны 1 дүгээр улиралд 134.3 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 3.3 хувь, өмнөх улирлаас 3.5 хувиар тус тус өссөн байна.

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2022 оны 1 дүгээр улиралд 111.7 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 4.5 хувь, өмнөх улирлаас 2.0 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар



Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 3.5 хувиар өсөхөд богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 3.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Түүнчлэн зочид буудлын үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ аймагт 15.3 хувь, нийслэлд 1.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2022 I-III	2022 I-III	2022 I-III
	2015	2021 I-III	2021 X-XII
	2015=100		
<b>Ерөнхий индекс</b>	<b>134.3</b>	<b>103.3</b>	<b>103.5</b>
Богино хугацаагаар байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	133.7	103.0	103.2
Автомашинны зогсоол бүхий зуслан, чөлөөт цаг өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа	160.4	100.6	99.2
Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа	131.5	134.2	129.7

ХҮСНЭГТ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	<u>2022 I-III</u>	<u>2022 I-III</u>	<u>2022 I-III</u>
	2015	2021 I-III	2021 X-XII
	2015=100		
<b>Ерөнхий индекс</b>	<b>134.3</b>	<b>103.3</b>	<b>103.5</b>
Нийслэл	131.3	100.2	101.7
Аймаг	156.0	127.5	115.3

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өсөхөд нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ аймагт 12.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 3. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	<u>2022 I-III</u>	<u>2022 I-III</u>	<u>2022 I-III</u>
	2015	2021 I-III	2021 X-XII
	2015=100		
<b>Ерөнхий индекс</b>	<b>111.7</b>	<b>104.5</b>	<b>102.0</b>
Нийслэл	110.1	103.3	101.3
Аймаг	123.3	112.9	106.8

**Ойлголт, тодорхойлолт**

**Үйлдвэрлэгчийн үнийн индекс:** Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

**Индексийн жин:** Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

**Тооцох аргачлал:** Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_P^L = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

$I_P^L$  –  $t$  тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

$t$  – тайлант үе

$0$  – суурь үе

$p_t^i$  –  $i$  барааны тайлант үеийн үнэ

$p_0^i$  –  $i$  барааны суурь үеийн үнэ

$q_0^i$  –  $i$  барааны суурь үеийн худалдан авсан тоо



**Эх үүсвэр:**

ҮСХ, Зочид буудал, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

**Ангилал, код:**

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;  
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал;

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ гархаах хуваарь:**

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-51)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Д.Мөнхтуул  
Утас : (976-51)-261559

